








# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛМОГО - 2020



<http://www.ubstat.mn>



## ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Монгол Улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, 2020 оны 208 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын А/1282 тоот захирамж, дүүргийн Засаг Даргын А/497 тоот захирамжаар Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан тооллого явуулах удирдамж, зааврын дагуу 2020 оны мал, тэжээвэр амьтдын тооллогыг 12 сарын 18-наас 28-ны өдрүүдэд дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж явууллаа.

Энэхүү танилцуулгад орж байгаа статистикийн үзүүлэлтүүдийг дүүргийн мал, тэжээвэр амьтдын 2020 оны тооллогын мэдээллийг боловсруулж, Үндэсний Статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн, олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу тооцож, үр дүнг гаргалаа.

## ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх:** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

**Малчин өрх:** Жилийн 4 улирлын түршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эхүүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

**Малчид:** Жилийн 4 улирлын түршид мал аж ахуй гэрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

**Бодод шилжүүлэх коэффициент:**

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод,

6 хонь = 1 бод, 8 ямаа = 1 бод

**Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:**

1 тэмээ = 5 хонь, 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь

1 хонь = 1 хонь, 1 ямаа = 0.9 хонь

**Нас гүйцсэн мал:** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

**Өсвөр насны мал:**

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

**Төл мал:** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүрдээр сүүлийн 2 насны эх малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана.

Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоо гэх нийт малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь:** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 – гаар үржүүлнэ.

**Бойжилтын хувь:** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25 Азарга - 12-15 Бүх - 35-45 Хуц, үхна - 25-30

**Малын зүй бус хорогдол:** Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Малын хэрэглээний зарлага:**

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

2. Хүнсний хэрэглээний малын тоо= Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоодод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн – Худалдаж авсан, шилжижирсэн).

Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн. Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно. Идээгүй тохиолдолд тэнцэж байх учиртай.

**Малын хашааны хангамж:** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

**Тэжээл хангамж:** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг.

Үүний тулд дараахь итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.


|                      |      |
|----------------------|------|
| Хадлан өвс           | 0.45 |
| Таримал тэжээл       | 0.35 |
| Даршны ургамал       | 0.25 |
| Гартэжээл, хужир шүү | 1.0  |
| Төмс ногооны хаягдал | 0.22 |
| Үр тарианы хаягдал   | 0.9  |
| Лай                  | 0.4  |
| Сүрэл                | 0.25 |

**Малын тэжээлийн ангилал:** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

## МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Малын тоо, бүтэц:** Хан-Уул дүүрэгт 2020 оны мал тооллогоор нийт 46090 толгой мал тоологдсон нь 2019 оноос 7451 (19.3%) толгой малаар өссөн байна. Нийслэлийн хэмжээнд 2020 онд 468690 толгой мал тоологдсон бөгөөд дүүргийн мал 9.8 хувийг эзэлж байна.

Зураг 1. Дүүргийн нийт малын тоо, оноор



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад адуу 4371 толгойгоор (57.6%), үхэр 55 толгойгоор (0.5%), ямаа 3126 толгойгоор (35.3%) тус тус өссөн бол хонь 105 толгойгоор (1.0%) буурсан байна. Иргэдийн хувийн мал 45803 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 287 болж өмнөх оноос иргэдийн мал 7164 (18.5%) толгойгоор өссөн.

Хүснэгт 1. Малын тоо, төрлөөр

| Малын төрөл                 | 2015   | 2016   | 2017   | 2018   | 2019   | 2020   | Өсөлт, бууралт |         |
|-----------------------------|--------|--------|--------|--------|--------|--------|----------------|---------|
|                             |        |        |        |        |        |        | Тоо            | Хувь    |
| Малын тоо, бүгд             | 37520  | 38860  | 38485  | 33208  | 38639  | 46090  | 7451           | 19.3    |
| Тэмээ                       | 1      | 7      | 1      | 3      | 3      | 7      | 4              | 2.3 дах |
| Адуу                        | 5918   | 7451   | 6247   | 5745   | 7589   | 11960  | 4371           | 57.6    |
| Үхэр                        | 12043  | 12274  | 12616  | 11231  | 11845  | 11900  | 55             | 0.5     |
| Хонь                        | 9944   | 9958   | 9894   | 8576   | 10336  | 10231  | -105           | 99.0    |
| Ямаа                        | 9614   | 9170   | 9727   | 7653   | 8866   | 11992  | 3126           | 35.3    |
| Хонин толгойд шилжүүлснээр* | 132286 | 144047 | 138078 | 123080 | 142523 | 176179 | 33656          | 23.6    |

\* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

2020 онд дүүргийн 12-р хорооны мал 0.3 хувиар буурч, 13-р хорооных 6.8 хувиар, 14-р хорооных 31.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Малын тоо, хороогоор

| Хороо      | 2019  | 2020  | Үүнээс: малын төрлөөр |       |       |       |       | Өсөлт, бууралт, хувь |
|------------|-------|-------|-----------------------|-------|-------|-------|-------|----------------------|
|            |       |       | Тэмээ                 | Адуу  | Үхэр  | Хонь  | Ямаа  |                      |
| 12-р хороо | 4906  | 4889  | -                     | 799   | 2028  | 747   | 1315  | -0.3                 |
| 13-р хороо | 12853 | 13726 | 2                     | 2140  | 5259  | 2831  | 3494  | 6.8                  |
| 14-р хороо | 20880 | 27475 | 5                     | 9021  | 4613  | 6653  | 7183  | 31.6                 |
| Дүн        | 38639 | 46090 | 7                     | 11960 | 11900 | 10231 | 11992 | 19.3                 |

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 27475 толгой малаар 14-р хороо тэргүүлж, өмнөх оноос 6595 толгой малаар өссөн байна. Хамгийн цөөн малтай нь 12-р хороо 4889 толгой

малтай байна. 2020 онд нийт мал сүргийн 48.2 хувийг бог мал, 51.8 хувийг бод мал эзэлж байна. Нийт малын сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр нь дараахь хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3. Нийт малд эзлэх хувийн жин, малын төрлөөр

|          | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он |
|----------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|
| Нийт мал | 100.0   | 100.0   | 100.0   | 100.0   | 100.0   | 100.0   | 100.0   |
| Тэмээ    | 0.0     | 0.0     | 0.02    | 0.0     | 0.01    | 0.008   | 0.015   |
| Адуу     | 13.8    | 15.8    | 19.2    | 16.2    | 17.3    | 19.6    | 26.0    |
| Үхэр     | 26.0    | 32.1    | 31.58   | 32.8    | 33.8    | 30.7    | 25.8    |
| Хонь     | 33.6    | 26.5    | 25.6    | 25.7    | 25.8    | 26.8    | 22.2    |
| Ямаа     | 26.6    | 25.6    | 23.6    | 25.3    | 23.0    | 22.892  | 26.0    |

Нийт мал сүргийн 0.015 хувийг тэмээ, 25.8 хувийг үхэр, 26.0 хувийг адуу, 22.2 хувийг хонь, 26.0 хувийг ямаа эзэлж байна. Малын нийт дүнд эзлэх хувийн жинг өмнөх онуудтай харьцуулахад адууны эзлэх хувийн жин нэмэгдэж, хонь, үхрийн эзлэх хувийн жин багассан байна. Бог малын бүтцийн хувьд нийт бог малын 46.0 хувийг хонин сүрэг, 54.0 хувийг ямаан сүрэг эзэлж байна.


**Малтай өрх, малчдын тоо:** Хан-Уул дүүрэгт 2020 оны мал тооллогоор нийт 46090 толгой мал тоологдсон нь 2019 оноос 7451 (19.3%) толгой малаар өссөн байна. 2020 оны мал тооллогын дүнгээр хувийн малтай 729 өрх, үүний дотор 210 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Өнгөрсөн оноос малтай өрхийн тоо 55 өрхөөр нэмэгдэж, малчин өрхийн тоо 22 өрхөөр буурсан байна.

Хүснэгт 4. Малтай өрх, малчдын насны бүлгээр

| он   | Малтай өрхийн тоо | Малчин өрхийн тоо | Түүний ам бүлийн тоо | Малчдын тоо | Насны бүлэг      |             |                    |                      | Нийт малчдаас эмэгтэй |
|------|-------------------|-------------------|----------------------|-------------|------------------|-------------|--------------------|----------------------|-----------------------|
|      |                   |                   |                      |             | 15 хүртэлх насны | 15-34 насны | 35-59, 35-54 насны | 60,55-аас дээш насны |                       |
| 2007 | 984               | 293               | 947                  | 644         | -                | 223         | 250                | 171                  | 208                   |
| 2008 | 854               | 300               | 1098                 | 605         | -                | 212         | 235                | 164                  | 192                   |
| 2009 | 933               | 178               | 547                  | 178         | -                | 29          | 106                | 43                   | 62                    |
| 2010 | 937               | 176               | 609                  | 319         | -                | 58          | 164                | 97                   | 98                    |
| 2011 | 877               | 287               | 375                  | 421         | -                | 19          | 210                | 112                  | 158                   |
| 2012 | 840               | 56                | 201                  | 110         | -                | 31          | 63                 | 16                   | 50                    |
| 2013 | 809               | 100               | 356                  | 185         | -                | 42          | 125                | 18                   | 85                    |
| 2014 | 728               | 104               | 364                  | 209         | -                | 59          | 122                | 28                   | 100                   |
| 2015 | 816               | 106               | 385                  | 216         | -                | 57          | 140                | 19                   | 95                    |
| 2016 | 836               | 206               | 704                  | 389         | -                | 85          | 252                | 52                   | 164                   |
| 2017 | 809               | 153               | 610                  | 281         | 6                | 79          | 163                | 33                   | 108                   |
| 2018 | 700               | 182               | 602                  | 288         | -                | 75          | 185                | 28                   | 117                   |
| 2019 | 674               | 232               | 851                  | 352         | -                | 77          | 245                | 30                   | 145                   |
| 2020 | 729               | 210               | 757                  | 293         | -                | 55          | 212                | 26                   | 105                   |

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 18.8 хувь нь 16-34 насны, 72.3 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 8.9 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Нийт малчдын 105 буюу 35.8 хувь нь эмэгтэй малчид байна.

Зураг 2. Малчдын тоо, насны бүлгээр



Дүүргийн малчин өрх, малчдын тоог өнгөрсөн онтой харьцуулахад малчин өрхийн тоо 22 өрх (9.5%), малчдын тоо 59 хүнээр (16.8%) буурсан байна.

Малчин өрхийн 75.2 хувийг цахилгаан эх үүсвэртэй, 69.5 хувийг телевизортой өрх эзэлж байна.

**“Амины мал”-ын тоо:** Иргэдийн хувийн өмчийн малын тоо 2020 онд 45803 32988 толгой болж, нийт малын 99.4 хувийг эзэлж байна. Тоологдсон адууны 99.4 хувь, үхрийн 99.6 хувь, хонины 99.9 хувь, ямааны 98.7 хувийг хувийн өрхийн мал эзэлж байна.

Хүснэгт 5. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлтээр, 2020 он

| Малын бүлэглэлт | Малтай өрхийн тоо | Ам бүлийн тоо | Амины малын тоо | Үүнээс: малын төрлөөр |       |       |       |       |
|-----------------|-------------------|---------------|-----------------|-----------------------|-------|-------|-------|-------|
|                 |                   |               |                 | Тэмээ                 | Адуу  | Үхэр  | Хонь  | Ямаа  |
| 10 хүртэл       | 200               | 575           | 1100            | 1                     | 124   | 952   | 6     | 17    |
| 11-30           | 209               | 668           | 3892            | -                     | 1113  | 2545  | 63    | 171   |
| 31-50           | 99                | 320           | 3979            | 2                     | 1690  | 1926  | 148   | 213   |
| 51-100          | 114               | 411           | 7797            | -                     | 3347  | 3224  | 464   | 762   |
| 101-200         | 63                | 242           | 8478            | -                     | 3354  | 1645  | 1461  | 2018  |
| 201-500         | 30                | 106           | 9806            | 4                     | 1561  | 975   | 2865  | 4401  |
| 501-999         | 11                | 43            | 7087            | -                     | 496   | 374   | 3614  | 2603  |
| 1000-1499       | 2                 | 8             | 2150            | -                     | 10    | 88    | 935   | 1117  |
| 1500-2000       | 1                 | 2             | 1514            | -                     | 193   | 120   | 663   | 538   |
| Дүн             | 729               | 2375          | 45803           | 7                     | 11888 | 11849 | 10219 | 11840 |

Дүүргийн малтай нэг өрхөд 62.8 толгой мал, бодод шилжүүлснээр 36.9 толгой мал ногдож байна. Малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 19.3 толгой мал, бодод шилжүүлснээр 11.3 толгой мал ногдож байна.

**Мал төллөлт, төл бойжилт:** 2020 онд 12570 хээлтэгч мал төллөж, 12619 төл гарсны 12025 төл (95.3%) нь бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 1055 толгойгоор (8.1%) буурсан.

Зураг 3. Бойжуулсан төл, оноор



Бойжуулсан нийт төлийн 14.2 хувийг унага, 36.4 хувийг тугал, 26.4 хувийг хурга, 23.0 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 6. Төл бойжилт, төрлөөр

|                | 2019  | 2020  | Үүнээс: |       |       |       |      |
|----------------|-------|-------|---------|-------|-------|-------|------|
|                |       |       | Ботго   | Унага | Тугал | Хурга | Ишиг |
| Гарсан төл     | 13166 | 12619 | -       | 1749  | 4500  | 3393  | 2977 |
| Бойжсон төл    | 13080 | 12025 | -       | 1703  | 4373  | 3181  | 2768 |
| Хорогдсон төл  | 86    | 594   | -       | 46    | 127   | 212   | 209  |
| Бойжилтын хувь | 99.3  | 95.3  | -       | 97.4  | 97.2  | 93.8  | 93.0 |

2020 оны мал тооллогоор нийт 12619 гарсан төлийн 594 (4.7%) толгой нь хорогдож, төл бойжилт 95.3 хувьтай байна. Хорогдсон төл малын тоо 2019 оныхоос 508 толгойгоор нэмэгджээ. Нийт хорогдсон төлийн 7.7 хувийг унага, 21.4 хувийг тугал, 35.7 хувийг хурга, 35.2 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 7. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

| Төрөл | Төллөсөн хээлтэгч | Гарсан төл | Хорогдсон төл | Бойжсон төл | Худалдаж авсан | Шилжиж ирсэн | Худалдсан | Шилжүүлсэн |
|-------|-------------------|------------|---------------|-------------|----------------|--------------|-----------|------------|
| Ботго | -                 | -          | -             | -           | 1              | -            | -         | -          |
| Унага | 1749              | 1749       | 46            | 1703        | 20             | 585          | 77        | 38         |
| Тугал | 4498              | 4500       | 127           | 4373        | 192            | 306          | 1062      | 210        |
| Хурга | 3375              | 3393       | 212           | 3181        | 56             | 389          | 383       | 13         |
| Ишиг  | 2948              | 2977       | 209           | 2768        | 64             | 535          | 467       | 27         |
| Бүгд  | 12570             | 12619      | 594           | 12025       | 333            | 1815         | 1989      | 288        |



2020 онд нийт 12025 төл бойжуулсан, 333 төл бусдаас худалдан авсан, 1815 төл шилжиж ирсэн байна. Мөн 1989 төлийг бусдад худалдаж, 288 төлийг шилжүүлсэн байна. 2020 онд худалдсан төлийг төрлөөр нь авч үзвэл: унага 77 толгой, тугал 1062 толгой, хурга 383 толгой, ишиг 467 толгой төл худалджээ.

**Бэлэн тоологдсон төл:** 2020 оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 11896 толгой болж өнгөрсөн оныхоос 55 толгой (0.5%) төлөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

| Төрөл | 2014  | 2015  | 2016  | 2017  | 2018 | 2019  | 2020  | 2020/2019 |       |
|-------|-------|-------|-------|-------|------|-------|-------|-----------|-------|
|       |       |       |       |       |      |       |       | хувь      | зөрүү |
| Ботго | 1     | -     | -     | -     | -    | -     | 1     | -         | 1     |
| Унага | 1026  | 1055  | 1069  | 1010  | 712  | 1701  | 2193  | 128.9     | 492   |
| Тугал | 3694  | 3981  | 3433  | 4116  | 3028 | 3898  | 3599  | 92.3      | -299  |
| Хурга | 4415  | 3288  | 3223  | 3369  | 2386 | 3432  | 3230  | 94.1      | -202  |
| Ишиг  | 3350  | 2952  | 2424  | 2973  | 1746 | 2810  | 2873  | 102.2     | 63    |
| Бүгд  | 12486 | 11276 | 10149 | 11468 | 7872 | 11841 | 11896 | 100.5     | 55    |

**Том малын зүй бус хорогдол:** Оны эхний малын 3.4 хувьтай тэнцэх 1323 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 2.4 дахин нэмэгджээ. Хорогдсон нийт малын 7.4 хувийг адуу, 22.7 хувийг үхэр, 40.4 хувийг хонь, 29.5 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 44 толгой (3.3%) мал өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 9. Том малын зүй бус хорогдол

| Үзүүлэлт                  | 2019 | 2020 | Үүнээс: |      |      |      |      |
|---------------------------|------|------|---------|------|------|------|------|
|                           |      |      | Тэмээ   | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
| Хорогдсон том мал         | 383  | 1323 | -       | 98   | 300  | 535  | 390  |
| Үүнээс: Өвчнөөр хорогдсон | 16   | 44   | -       | 2    | 37   | 5    | -    |
| Хорогдсон хээлтэгч        | 143  | 0    | -       | -    | -    | -    | -    |

**Малын хэрэглээний орлого зарлага:** 2020 онд оны эхний нийт малын 1973 (5.1%) толгой малыг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 30.0 хувийг хонь, 19.1 хувийг ямаа, үлдсэн 50.9 хувийг бод мал эзэлж байна.

Хүснэгт 10. Малын хэрэглээний орлого, зарлага, төрлөөр

| Төрөл | Орлого         |              |                      | Хасагдсан  |                                      |                      |                    |                  |  |
|-------|----------------|--------------|----------------------|------------|--------------------------------------|----------------------|--------------------|------------------|--|
|       | Худалдаж авсан | Шилжиж ирсэн | Бэлэн тоологдсон төл | Шилжүүлсэн | Алдсан, кугайлагдса нолдохгүй байгаа | Зах зээлд борлуулсан | Хүнсэнд хэрэглэсэн | Зүй бус хорогдол |  |
| Тэмээ | 2              | 1            | 1                    | -          | -                                    | -                    | -                  | -                |  |
| Адуу  | 313            | 3901         | 2193                 | 1088       | 80                                   | 617                  | 153                | 98               |  |
| Үхэр  | 517            | 926          | 3599                 | 1175       | 63                                   | 2598                 | 851                | 300              |  |
| Хонь  | 306            | 989          | 3230                 | 1211       | 46                                   | 2247                 | 591                | 535              |  |
| Ямаа  | 621            | 2206         | 2873                 | 527        | 64                                   | 1215                 | 378                | 390              |  |
| Дүн   | 1759           | 8023         | 11896                | 4001       | 253                                  | 6677                 | 1973               | 1323             |  |

Дээрх хүснэгтээс харахад энэ жилийн малын орлого талд тооллогоор худалдаж авсан 1759 толгой, бэлэн тоологдсон төл 11896 толгой, шилжиж ирсэн 8023 толгой мал байна. Харин шилжүүлсэн 4001 толгой мал, зүй бусаар 1323 толгой мал хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн 1973 толгой мал, 6677 толгой малыг зах зээлд борлуулсан нь зарлага талын үзүүлэлтийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11. Малын тооны өөрчлөлтөд нөлөөлсөн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт                     | 2016  | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2020/2019 |       |
|------------------------------|-------|-------|-------|-------|-------|-----------|-------|
|                              |       |       |       |       |       | тоо       | Хувь  |
| Бэлэн тоологдсон төл         | 10149 | 11468 | 7872  | 11841 | 11896 | 55        | 100.5 |
| Том малын зүй бусын хорогдол | 751   | 1070  | 1775  | 383   | 1323  | 940       | 345.4 |
| Хээлтэгч малын тоо           | 17812 | 17833 | 16737 | 17716 | 20736 | 3020      | 117.0 |
| Хээл хаясан хээлтэгч         | 762   | 531   | 1084  | 519   | 450   | -69       | 86.7  |
| Сувайрсан хээлтэгч           | 2710  | 2313  | 4531  | 2800  | 3084  | 284       | 110.1 |

2020 онд бэлэн тоологдсон төл 0.5 хувиар, хээлтэгч малын тоо 17.0 хувиар, том малын зүй бусын хорогдол 245.4 хувиар, сувайрсан хээлтэгч 10.1 хувиар өсөж, хээл хаясан хээлтэгч 13.3 хувиар буурсан байна.

**Малын хээл хаялт, сувайралт:** 2020 онд оны эхний хээлтэгч малын 19.9 хувьтай тэнцэх хээлтэгч мал төл өгөөгүй ба үүний 3084 эх мал сувайрсан, 450 эх мал хээл хаясан байна. Энэ нь өмнөх оноос сувайрсан мал 284 толгойгоор нэмэгдэж, хээл хаясан мал 69 толгойгоор буурсан байна. Нийт төл өгөөгүй хээлтэгч малын 52.4 хувийг бог эзэлж байна.

Хүснэгт 12. Сувайрсан болон хээл хаясан мал, төрлөөр

| Төрөл   | Төл өгөөгүй хээлтэгч мал |      |      | Үүнээс:   |      |      |             |      |      |   |
|---------|--------------------------|------|------|-----------|------|------|-------------|------|------|---|
|         |                          |      |      | Сувайрсан |      |      | Хээл хаясан |      |      |   |
|         | 2018                     | 2019 | 2020 | 2018      | 2019 | 2020 | 2018        | 2019 | 2020 |   |
| Ингэ    | -                        | -    | -    | -         | -    | -    | -           | -    | -    | - |
| Гүү     | 1036                     | 575  | 781  | 776       | 535  | 707  | 260         | 40   | 74   |   |
| Үнээ    | 1735                     | 993  | 954  | 1549      | 918  | 888  | 186         | 75   | 66   |   |
| Эм хонь | 1314                     | 857  | 961  | 1101      | 607  | 747  | 213         | 250  | 214  |   |
| Эм ямаа | 1530                     | 894  | 838  | 1105      | 740  | 742  | 425         | 154  | 96   |   |
| Бүгд    | 5615                     | 3319 | 3534 | 4531      | 2800 | 3084 | 1084        | 519  | 450  |   |

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Дүүргийн нийт мал сүргийн 11896 (25.8%) нь төл мал, 20736 (45.0%) нь хээлтэгч мал, 773 нь хээлтүүлэгч мал байна. Малын үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад дүүргийн хувьд нэг хээлтүүлэгчид дунджаар 98.7 эм хонь, 112.0 эм ямаа ногдож, хээлтүүлгийн тохироо алдагдсан байна.

Хүснэгт 13. Хээлтүүлэгч малын тоо


| Төрөл  | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | Өсөлт, бууралт /тоо/ |
|--------|------|------|------|------|------|------|------|------|----------------------|
| Бүүр   | -    | 2    | -    | -    | -    | -    | -    | -    | -                    |
| Азарга | 346  | 331  | 345  | 418  | 325  | 350  | 424  | 557  | 133                  |
| Бүх    | 92   | 98   | 97   | 114  | 106  | 110  | 110  | 110  | -                    |
| Хуц    | 86   | 114  | 71   | 56   | 56   | 41   | 47   | 52   | 5                    |
| Ухна   | 90   | 91   | 77   | 55   | 48   | 36   | 39   | 54   | 15                   |
| Бүгд   | 614  | 636  | 590  | 643  | 535  | 537  | 620  | 773  | 153                  |

**Хээлтэгч мал:** 2020 оны мал тооллогоор 20736 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 3020 толгой (17.0%) малаар өссөн байна. Хээлтэгч малын өсөлтөд гүү 1211 толгой, эм хонь 27 толгой, эм ямаа 2070 толгойгоор өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 14. Хээлтэгч мал, төрлөөр

| Төрөл   | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  | 2020  | Өсөлт, бууралт |       |
|---------|-------|-------|-------|-------|-------|-------|----------------|-------|
|         |       |       |       |       |       |       | тоо            | хувь  |
| Ингэ    | -     | 4     | 1     | 1     | -     | 1     | 1              | 0     |
| Гүү     | 1591  | 2207  | 1966  | 2158  | 2630  | 3841  | 1211           | 146.0 |
| Үнээ    | 5585  | 6072  | 6259  | 6105  | 6000  | 5711  | -289           | 95.2  |
| Эм хонь | 4833  | 4957  | 4782  | 4434  | 5105  | 5132  | 27             | 100.5 |
| Эм ямаа | 4563  | 4572  | 4629  | 4039  | 3981  | 6051  | 2070           | 152.0 |
| Бүгд    | 16572 | 17812 | 17637 | 16737 | 17716 | 20736 | 3020           | 117.0 |

Зураг 4. Хээлтэгч малын тоо



2020 онд дүүргийн нийт малын 45.0 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Үүнд: адуун сүргийн 32.1 хувь, үхэр сүргийн 48.0 хувь, хонин сүргийн 50.2 хувь, ямаан сүргийн 50.5 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

**Бэлтгэсэн хадлан тэжээл:** Дүүргийн хэмжээнд 2020 онд 6664.2 тонн хадлан, гар тэжээл 1235.5 тонн, хужир шүү 146.6 тонныг тус тус бэлтгэсэн байна. 2019 онтой харьцуулахад хадлан 1065.2 тонн (19.0%)-оор өсөж, хужир шүү 134.4 тонн (47.8%), гар тэжээл 30.0 тонн (2.4%)-оор буурсан байна.

Хүснэгт 15. Бэлтгэсэн хадлан тэжээл, тн

| Бэлтгэсэн хадлан тэжээл | 2017   | 2018   | 2019   | 2020   | Өсөлт,<br>бууралт |
|-------------------------|--------|--------|--------|--------|-------------------|
| Хадлан                  | 5464.5 | 5205.1 | 5599.0 | 6664.2 | 119.0             |
| Гар тэжээл              | 1915.3 | 1282.9 | 1265.5 | 1235.5 | 97.6              |
| Хужир шүү               | 204.4  | 102.4  | 281.0  | 146.6  | 52.2              |

2020 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор 897 малын хашаа, 246 худаг тоологдсон нь 2019 оноос малын хашаа 7.5 хувиар буурсан бол худаг 26.2 хувиар нэмэгдсэн байна.

**Тэжээвэр амьтад:** Мал, тэжээвэр амьтдын 2020 оны тооллогоор 53 өрх, 10 аж ахуйн нэгжийн 3610 гахай, түүлай 230, цацагт хяруул 36, галуу 50, 483300 шувуу, үүнээс 482860 тахиа тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад шувуу болон тахианы тоо 13.1 хувиар өссөн бол гахайн тоо 6.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 16. Тэжээвэр амьтдын тоо

| Үзүүлэлт      | 2015   | 2016   | 2017   | 2018   | 2019   | 2020   |
|---------------|--------|--------|--------|--------|--------|--------|
| Гахай         | 5926   | 5007   | 4174   | 3753   | 3847   | 3610   |
| Шувуу         | 269307 | 322527 | 360722 | 391542 | 427437 | 483300 |
| Үүнээс: тахиа | 268837 | 321340 | 360201 | 391114 | 427062 | 482860 |
| Зөгийн бүл    | 10     | 11     | -      | -      | -      | -      |

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2020 онд 187.6 тонн гахайн мах, 156.7 тонн шувууны мах, 105.1 сая ширхэг өндөг нийт 28.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

**Гэрийн тэжээвэр муур, нохой:** Дүүргийн 21 хороонд гэрийн тэжээвэр 5126 нохой, 230 муур байна. Бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохойн тоо 259 (4.8%)-аар буурсан бол муурны тоо 79 (52.3%)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 17. Тэжээвэр нохой, муурны тоо, хороогоор

| Хороо      | Нохой |      |                | Муур |      |                |
|------------|-------|------|----------------|------|------|----------------|
|            | 2019  | 2020 | Өсөлт, бууралт | 2019 | 2020 | Өсөлт, бууралт |
| 1-р хороо  | 23    | 21   | 91.3           | 1    | 3    | 3 дах          |
| 2-р хороо  | 15    | 20   | 133.3          | 2    | 5    | 2.5 дах        |
